

“Цаг уурын радарын инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн сургалтад оролцсон ажлын тайлан

Оролцсон бүрэлдэхүүн:

- НЦУТ-ийн радарын инженер Ч.Наранбаатар
- УЦУОСМХ-ийн ЦАОТЗС Хэлтсийн дарга Г.Батжаргал

Сургалт 2025 оны 6 дугаар сарын 16-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын нийслэл Сөүл хотноо Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн сургалтын төв болох БНСУ-ын Цаг уурын газарт зохион байгуулсан.

Энэхүү сургалтын үндсэн зорилго нь Цаг уурын радарын онол, техник хангамж, радарын үйл ажиллагаа, Цаг уурын үзэгдэлд дүн шинжилгээ хийх бүтээгдэхүүнүүдийн тухай мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх юм. Мөн гамшигт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх боломжийг нэмэгдүүлэх болно. Ингэснээр Цаг уурын урьдчилсан мэдээ гаргахад шаардлагатай радарын бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлчлэхэд туршлага судлах чухал ач холбогдолтой юм.

Сургалтын хугацаанд дараах агуулга бүхий бүлэг хичээлийг үзэж судалсан.

Нэгдүгээр бүлэг: БНСУ-ын Цаг уурын газрын танилцуулга

1. БНСУ-ын хэл болон соёл
2. БНСУ-ын Цаг уурын газрын үйл ажиллагааны танилцуулга болон гадаад хамтын ажиллагаа.

Хоёрдугаар бүлэг: Цаг уурын радарын үндэс

1. Зайнаас тандан судлалын зарчим ба онцлог
2. Цаг уурын радарын системийн бүтэц
3. Цаг уурын радарын ажиглалтын онол, стратеги

Гуравдугаар бүлэг: Цаг уурын радарын ашиглалт

1. Цаг уурын радарын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тохируулга
2. Цаг уурын радарын үзлэг, үйлчилгээ
3. Хос туйлшралтай (Dual Polarization) радарын үндэс ба зургийн анализ
4. Радарын мэдээллийн чанарын хяналт, хур тунадас тооцоолол
5. Радарын мэдээнд суурилсан урьдчилсан мэдээ ба тухайлсан судалгаа
6. Цаг уурын радарын ашиглалт ба шалгалт тохируулга.

Дөрөвдүгээр бүлэг: Сургалтын идэвхжүүлэлт

1. Сургалтад хамрагдаж буй улс орнуудын цаг уурын радарын ашиглалтын талаар танилцуулга
2. Цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, танилцуулах

Тавдугаар бүлэг: Соёлын туршлага

1. Соёлын үйл ажиллагаанд оролцох.

Эдгээр сэдвийн дагуу холбогдох албаны судлаач, ажилчид дэлгэрэнгүй лекц танилцуулж, сургалтад оролцогчидтой сонирхсон асуултын дагуу дэлгэрэнгүй ярилцлага өрнүүлсэн.

ЦУОШГ-т тавих санал:

- Цаашид шинээр тавих радарыг С эсвэл S сувгийн Хос туйлшралтай радар байхаар төлөвлөж нэвтрүүлэх. Учир нь өргөн уудам газар нутагтай манай улсад хамрах хүрээ их радарын техник шаардлагатай ба Х сувгийн радар нь хамрах хүрээ бага болон долгионы сарнил их тул үүл тунадсыг дутуу илрүүлэх сул талтай байдаг байна.



Тайлан бичсэн: НЦУТ-ийн радарын инженер Ч.Наранбаатар

2025-07-02